



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 15 өдөр

Дугаар A/152

Бор-Өндөр сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны "2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай" 14 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Төрийн байгууллагын зайлшгүй хэрэгцээнд зориулан эзэмшүүлэхээр тусгагдаж батлагдсан газарт хүсэлт гаргасан байгууллагад нэгдүгээр хавсралтад зааснаар газрыг эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээ авсан байгууллагын дарга, захиралтай гэрээ байгуулан гэрээнд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Т.Эрдэнэзаяа)-д, гэрээнийхээ дагуу газраа эзэмшин, жил бүр гэрээгээ дүгнүүлж байхыг газар эзэмшигчид үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ

Сумын Засаг даргын 2024 оны
08 дугаар сарын 15-ны өдрийн
А/152 дугаар захирамжийн 1-р хавсралт

Газар эзэмшигч болон газрын мэдээлэл

Д/д	Газар эзэмшигч		Газрын			
	Хуулийн этгээдийн нэр	Регистр	Хэмжээ /м ² /	Нэгж талбарын дугаар	Зориулалт	Хугацаа /жил/ Байршил
1	Монголросцветмет ТӨҮГ-ын харъяа Уулын баяжуулах Бор-Өндөр үйлдвэр	2550466	2887	3764751	2101: Төрийн захираганы байгууллага	40 1-р баг Бор-Өндөр, Үйлдвэрийн зам-1 гудамж, 101 тоот